<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>37,102,415.04</b>	<b>37,102,415.04</b>	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	37,102,415.04	37,102,415.04	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	24,193,599.73	24,193,599.73	-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	23,519,999.73	23,519,999.73	-
210101	Үндсэн цалин	-	23,519,999.73	23,519,999.73	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	117,600.00	117,600.00	-
210401	Бичиг хэрэг	-	117,600.00	117,600.00	-
2106	Эд хогшил худалдан авах	-	556,000.00	556,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	556,000.00	556,000.00	-
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>12,908,815.31</b>	<b>12,908,815.31</b>	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	12,908,815.31	12,908,815.31	-
261090	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,908,815.31	12,908,815.31	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>37,102,415.04</b>	<b>37,102,415.04</b>	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	37,102,415.04	37,102,415.04	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	23,755,200.00	23,755,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	556,000.00	556,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,791,215.04	12,791,215.04	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Барилгын политехник коллежийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Барилгын политехник коллежийн захирал Г.Нямдулам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомж, Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийг дагаж мөрдөх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Азуре хүлүг аудит” ХХК-ийн захирал Г.Мөнхбаяр, чанарын хяналтын менежер С.Оюунцэцэг, аудитор П.Энхтуяа, аудиторын туслах П.Болортуяа, Б.Тамир нар хариуцаж хэрэгжүүлэв.

Барилгын политехник коллеж нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газар болон “Азуре хүлүг аудит” ХХК-д 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 3/10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Барилгын политехник коллежийн эрхэм зорилго нь мэдлэг чадвар, хандлагаараа олон улсын жишигт нийцсэн бүтээн байгуулалтын салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх болно.

Барилгын политехник коллеж нь мэргэжлийн боловсрол олгох анхан шатны сургалтыг 10 мэргэжлээр, техникийн боловсрол олгох сургалтыг 8 мэргэжлээр, мэргэжил олгох сургалтыг 10 мэргэжлээр, богино хугацааны сургалтыг 10 мэргэжлээр, герман хэлний В1 түвшний сертификат олгох сургалтыг тус тус явуулдаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 472 дугаар тогтоол;
- Засгийн газрын “Журам батлах тухай” 2019 оны 5 дугаар тогтоол;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 2020 оны 49 дүгээр тогтоол



### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Барилгын политехник коллеж нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайланд онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тус коллежийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,524,687.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 35,246.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Барилгын политехник коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,609.1 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20.6	19.6	(1.0)
Авлага	40,754.2	62,540.4	21,786.2
Урьдчилгаа	1,000.2	6,655.1	5,654.9
Бараа материал	342,370.9	462,439.4	120,068.5
Үндсэн хөрөнгө	3,702,646.2	3,608,746.6	(93,899.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,086,792.1</b>	<b>4,140,401.2</b>	<b>53,609.1</b>
Өр төлбөр	64,899.6	64,211.4	(688.2)
Засгийн газрын оролцоо	4,022,413.2	4,022,413.2	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,086,792.2</b>	<b>4,140,401.2</b>	<b>53,609.1</b>

Авлага дансны үлдэгдэл 62,540.4 мянган төгрөг болж өмнөх оноос 21,786.2 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд хувь хүмүүсээс авах авлага буюу сургалтын төлбөрийн авлага нийт авлагын 74.8 хувь буюу 46,807.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 17,309.1 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Мөн тайлант онд нийт авлагын 20.6 хувь буюу 12,908.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 4.5 хувь буюу 2,824.3 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага тус тус шинээр үүссэн байна. Авлагын насжилтыг авч үзвэл 30-60 хоногийн насжилттай 45,365.5 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн авлага болон 421.0 мянган төгрөгийн бусад авлага, 30 хүртэл хоногийн насжилттай 16,753.8 мянган төгрөгийн авлага байна.



Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 1,000.2 мянган төгрөг байсан бол тайлант онд оюутны байрны цахилгааны төлбөрт 4,577.9 мянган төгрөг, хичээлийн байрны дулааны төлбөрт 2,077.2 мянган төгрөгийг шилжүүлж, нийт 6,655.1 мянган төгрөгийн урьдчилж төлсөн тооцоо шинээр үүссэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 342,370.9 мянган төгрөг байсан бол тайланд хугацаанд 134,276.1 мянган төгрөгийн худалдан авалт, Германы хамтын ажиллагааны байгууллагаас 58,208.1 мянган төгрөгийн, Азийн хөгжлийн банкны төслөөс 73,634.4 мянган төгрөгийн нийт 143,061.6 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнгээр нэмэгдэж, 157,269.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 462,439.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Оны эцэст 8,798.4 мянган төгрөгийн хичээл дадлагын материал, бичгийн цаас, хангамжийн материал худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь шалгагдагч этгээдийн байр ашиглалт, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах зорилготой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,608,746.6 мянган төгрөг болж, өмнөх тайлант үеэс 93,899.5 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 21,839.0 мянга, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хөдөлмөр эрхлэх ур чадвар дээшлүүлэх төслөөс 92,243.8 мянган төгрөгийн, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг төслөөс 27,722.2 мянган төгрөгийн, Койка төслөөс 5,136.0 мянган төгрөгийн хөрөнгүүд хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөөр, программ хангамж дансны бүртгэлээс бусад биет бус хөрөнгө данс руу шилжүүлсэн 6,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна. Мөн ТӨБЗГ-ын 2020 оны А-1/147 тогтоолын дагуу акталсан 45 нэр төрлийн 91,974.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 64,899.6 мянган төгрөг байсан бол тайлант онд 64,211.4 мянган төгрөг болж 688.2 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд, богино хугацаат өр төлбөр 7,687.2 мянган төгрөгөөр өссөн бол 8,375.5 мянган төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна. Богино хугацаат өр төлбөрийн хувьд дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 19,693.7 мянган төгрөг, урьдчилж орсон сургалтын төлбөр, оюутны барьцаа, түрээсийн орлого 29,540.5 мянган төгрөг, цалингаас суутгасан ХХОАТ болон цалингийн өглөг зэрэг ажилчидтай холбоотой өглөг 5,960.1 мянган төгрөг байна.

Бусад 9,017.0 мянган төгрөгийн өр төлбөр нь тус коллежийн бараа материал худалдан авахтай холбоотой 3,834.0 мянган төгрөг, үйлдвэрчний эвлэлд төлөх 90.0 мянган төгрөг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төлөх түрээсийн төвлөрүүлэх орлого 2,071.4 мянган төгрөг болон хувь хүмүүстэй холбоотой 3,041.6 мянган төгрөг байна.

Тайланд онд аливаа урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,022,413.2 мянган төгрөг бөгөөд тайлант онд аливаа өөрчлөлт ороогүй байна.

Барилгын политехник коллежийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 396,083.4 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 265,794.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал 447,954.6 мянган төгрөгөөр тус тус өссөн, харин үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого 307,682.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого буюу оюутны байрны төлбөр, түрээсийн төлбөр болон бусад орлого 46,173.7 мянган төгрөгөөр тус тус буурч материаллаг өөрчлөлт гарсан байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор оюутны байрны төлбөрийн орлого буурсан төдийгүй Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр түрээсийн

орлого төвлөрүүлэх хувийг өсгөсөн нь туслах үйл ажиллагааны орлого буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 201,827.9 мянган төгрөгөөр буюу 6.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалин 86,745.5 мянган төгрөг, нэмэгдэл цалин 222,592.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 39,392.8 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 40,848.3 мянган төгрөгөөр тус тус өссөн, харин хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 129,213.0 мянган төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал 52,975.4 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 82,079.2 мянган төгрөгөөр тус тус буурсан зэрэг зардлууд байна.

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоосон, мөн 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохоор заасны дагуу тус коллежийн цалин, нэмэгдлийн зардал өссөн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,189,095.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,189,095.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,983.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,195,095.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 4 удаа батлагдсан төсөвт өөрчлөлт орж, нийт 26,464.5 мянган төгрөгөөр бууруулж, 3,168,613.7 мянган төгрөг болсон байна. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 2,968,325.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 200,288.0 мянган төгрөгийг тус коллежийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Улсын төсвөөс 2,968,325.7 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн олгогдсон байна.

Үйл ажиллагааны орлогыг 200,288.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч 43.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 87,656.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнд, техникийн боловсрол олгох сургалт, богино хугацааны сургалт болон дахин шалгалтын төлбөр зэрэг үндсэн үйл ажиллагааны орлого нь 75,439.5 мянган төгрөгөөр, оюутны байрны төлбөр, түрээсийн төлбөр болон бусад орлого зэрэг туслах үйл ажиллагааны орлого 37,191.5 мянган төгрөгөөр тасалдсан байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор хичээл, сургалтын төдийгүй оюутны байрны үйл ажиллагаа хязгаарлагдсан нь тус коллежийн өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө тасалдах шалтгаан болсон байна.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 3,011,987.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 43,996.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Унаа болон бусад нөхөн олговрын зардал 79,232.6 мянган төгрөгөөр, урамшууллын зардлыг 36,619.0 мянган төгрөгөөр, ажилгүйдлийн болон эрүүл мэндийн даатгалын зардал 2628.4 мянган төгрөгөөр тус тус өссөн хэдий ч тээвэр шатахууны зардлыг 41,420.4 мянган төгрөгөөр, хоол, хүнсний зардлыг 27,244.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,011,987.4 мянган төгрөг буюу 4.9 хувийн хэмнэлттэй гарахад нөлөөлсөн байна.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор 12 дугаар сарын 15-ны өдрөөс хойш оюутны байранд суралцагчдыг байршуулаагүйгээс хүүхдийн хоолны зардал буурсан хэдий ч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан бус шийдвэрийн дагуу 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 12 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл нэмэлт хоолны зардалд нэг хүүхдийн 2.0 мянган төгрөг буюу 8,460.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус коллеж нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгтэй байгуулсан гэрээний дагуу хандив тусламжаар 23,755.2 мянган төгрөг, өмнөх оны нэмэлтээс төвлөрүүлсэн 556.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу оюутны байрны барьцаа 12,690.0 мянган төгрөг, нийт 37,001.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг төвлөрүүлжээ.

Үүнээс 23,519.9 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд, 117.6 мянган төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 556.0 мянган төгрөгийг эд хогшил худалдан авахад, нийт 24,193.5 мянган төгрөгийг зарцуулж, 12,908.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,904.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 9,723.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 8,471.5 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлснээс акт, албан шаардлага бүрэн хэрэгжиж, зөвлөмжийн хэрэгжилт 98 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,904.0	1	2,904.0	-	-	-
Албан шаардлага	1	9,723.0	1	9,723.0	-	-	-
Зөвлөмж	6	8,471.5	6	8,471.5	-	-	-
Нийт дүн		21,098.5		21,098.5	-	-	-

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 68,808.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58,276.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,071.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,460.0 мянган төгрөгийн алдааг зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 58,276.8 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хандив тусламжаар авсан хөрөнгийг нягтлан түүвэрлэн шалгахад Азийн хөгжлийн банкны хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслөөр хэрэгжсэн их засварын зардал 45,227.8 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүйг тайланд залруулав.
2. Санхүүгийн байдлын тайлан, авлага, өр төлбөрийн тодруулга тайланг тооцоо нийлсэн актуудын жагсаалттай тулган баталгаажуулахад цахилгаан, дулааны төлбөр болох 6,655.0 мянган төгрөгийг авлагын бүртгэлд бүртгээгүйг залруулав.
3. Тус коллежийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн элэгдлийн тооцооллыг нягтлан шалгахад тавилга эд хогшлын элэгдлийг 6,394.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 10,531.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2,071.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлэх түрээсийн орлогоос 2,071.4 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" 2020 оны 49 дүгээр тогтоолын 2, 5 дугаар заалттай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Шилэн дансны цахим сайтад 2020 оны 6 дугаар сард 6 мэдээллийг, 12 дугаар сард 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 8,460.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Үндсэн хөрөнгө, бараа материалыг олж бэлтгэх, зарцуулахтай холбоотой бүртгэл, тайлагнал болон өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Менежментийн захидал**

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### ***Зардлын данстай холбоотой асуудал***

#### **1.1 Илрүүлэлт:**

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлсний дагуу 8,460.0 мянган төгрөгийн нэмэлт хоол өгсөн байна.

#### **1.2 Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

#### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг тогтоосон хууль, тогтоомжид заасны дагуу төлөвлөн, түүнд үндэслэн хоолны зардлын хэрэгцээг гаргаж, илүү хөрөнгө зарцуулахгүй байх талаар шийдвэрлэж байх.

#### **1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Барилгын политехникийн коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			САГ-2021/316/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Барилгын политехникийн коллеж</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Түрээсийн орлогын холбогдох төлбөрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлээгүй байна.	2,071.4	Албан шаардлага өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Нямдулам Н.Нарансүрэн
5	Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай холбоотойгоор эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлсэн байна.	8,460.0	Зөвлөмж өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Нямдулам Н.Нарансүрэн
6	Шилэн дансны цахим сайтад оруулах 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.	-	Албан шаардлага өгөх	Захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Нямдулам Н.Нарансүрэн
<b>ДҮН</b>		<b>10,531.4</b>			





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 17/А0160062

Улаанбаатар хот

СЭГ- 2021/316/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Барилгын политехникийн коллежийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлэх түрээсийн орлогын төлбөрийг 2,071.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, мөн байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Түрээсийн орлогын төлбөрийг дутуу төвлөрүүлсэн, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан зэрэг зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын политехник коллежийн захирал Г.Нямдулам, нягтлан бодогч Н.Нарансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР  
"АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.ЭНХЖИН

Г.МӨНХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар 1.Docx

001081015

